



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/209

Ховд

Захирамжийн хэрэгжилтийг сунгах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай захирамжийн хэрэгжилтийг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цагаас 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2. Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ